



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ADB

ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ
САЙЖРУУЛАХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР



2020–2029



ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийг 2020–2029 онуудад хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Улаанбаатар хотын алслагдсан гэр хороолол болон зарим сумдын иргэдэд үзүүлэх анхан шатны болон лавлагаа шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлж, хувь хүнээс гарах зардлыг бууруулахад оршино.

ЗОРИЛТ 1: ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ БОЛОН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БЭХЖҮҮЛНЭ



Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чанар, санхүүжилт, хүний нөөцийн бодлогын шинэчлэлийг боловсруулж хэрэгжүүлнэ.



Улаанбаатар хотод үйлчлүүлэгчдэд ээлтэй, жендерийн мэдрэмжтэй 10 өрхийн эрүүл мэндийн төв, төслийн аймгуудад зургаан сумын эрүүл мэндийн төвийг барьж, ашиглалтад оруулж, оношилгоо эмчилгээнд нэн шаардлагатай суурин болон зөвөрийн тоног төхөөрөмжүүдийг ханган нийлүүлнэ. Үүнээс, гурван өрхийн эрүүл мэндийн төвийн барилгад газрын гүний дулааныг ашигласан нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг технологи нэвтрүүлнэ.



Үндэсний түргэн тусламжийн сүлжээг бүрдүүлж, түргэн тусламжийн үндэсний төвийн барилгыг шинээр барьж, эмнэлгийн болон харилцаа холбооны тоног, төхөөрөмжөөр тоноглон ашиглалтад оруулна.



Эмч мэргэжилтнүүдийг бэлтгэж сургана.




ҮР ДҮН 1

Үйлчлүүлэгчид ээлтэй эрүүл мэндийн төвөөр нийслэлийн гэр хорооллын болон сонгогдсон сумдын иргэд үйлчлүүлнэ.



ҮР ДҮН 2

Анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.



ҮР ДҮН 3

Улсын хэмжээнд түргэн тусламжийн үйлчилгээг нэгтгэн зангидах үндэсний төвтэй болж, амь тэнссэн үеийн оношилгоо, эмчилгээг цаг алдалгүй хүргэх нөхцөл бүрдэнэ.

ЗОРИЛТ 2: АЙМАГ, ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛНА



Эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд нэгдсэн эмнэлгийн төлөвлөлт, менежментийг сайжруулж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг бэхжүүлнэ.



Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт тусламж үйлчилгээ үзүүлэх амбулатори, хэвтүүлэн эмчлэх, өдрийн эмчилгээний тасгуудтай олон улсын стандартад нийцсэн, байгальд ээлтэй, нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг технологи нэвтрүүлсэн дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн барилгыг барьж, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийг ханган нийлүүлж суурилуулан ашиглалтад оруулна.



Увс аймгийн нэгдсэн эмнэлэг, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд дүрс оношилгоо, дуран, лаборатори, гемодиализ, мэс засал, эрчимт эмчилгээний тасагтай халдвар хамгааллын онцгой орчин бүрдүүлсэн өргөтгөлийн барилгыг шинээр барьж байгуулна.



Эмнэлгийн тоног төхөөрөмж, барилга, дэд бүтцийн засвар үйлчилгээнд төр хувийн хэвшлийн түншлэлийн загварыг боловсруулж, туршин хэрэгжүүлнэ.



Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн удирдлага, төлөвлөлтийг сайжруулах, эмч, сувилагч нарыг чадавхжуулах онол ба дадлагын сургалтуудыг зохион байгуулах ажлуудыг хэрэгжүүлнэ.



ҮР ДҮН 1

Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдэнэ.

ҮР ДҮН 2

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирч, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ.

ҮР ДҮН 3

Байгальд ээлтэй, нүүрс хүчлийн хий бага ялгаруулах, дулаан алдалт багатай технологи ашиглах нэгдсэн эмнэлгийн барилгын загвар шийдэл эрүүл мэндийн салбарт улам өргөжнө.



ЗОРИЛТ 3: ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛНЭ

Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэхэд эрүүл мэндийн салбарын стратегийн худалдан авалтын чадавхийг бэхжүүлэх, санхүүжилтийн үр ашгийг сайжруулахад Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Үүнд:



Эмнэлзүйн заавар, зардал үр дүнгийн шинжилгээнд үндэслэсэн цогц тусламж, үйлчилгээний багцыг тодорхойлно.



Өртөг зардлын судалгаанд суурилан төлбөрийн арга, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгоно.



Тусламж, үйлчилгээний хэрэглээ, салбарын хэмжээний нөөцийн хуваарилалтын үр ашгийг харгалзан үзэх замаар хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хангагдаагүй хэрэгцээг тодорхойлж, эрүүл мэндийн тогтолцоонд шаардлагатай байгаа шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

ҮР ДҮН 1

Тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд үндэслэсэн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлнэ.

ҮР ДҮН 2

Иргэдийн хувиасаа төлөх эрүүл мэндийн зардлыг бууруулж, эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн хүндрэлд орохоос сэргийлэх стратегийн худалдан авалтын тогтолцоог хэрэгжүүлнэ.

ЗОРИЛТ 4: ТӨРИЙН ӨМЧИТ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВАЛТ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Энэ зорилтын хүрээнд төрийн өмчит байгууллагуудын ажилтнуудад зориулсан худалдан авах ажиллагаа, санхүү болон эрсдэлийн удирдлагын сургалтын хөтөлбөрийг дэмжиж, чадавхыг бэхжүүлнэ.



ҮР ДҮН 1

Эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын худалдан авах үйл ажиллагааны чадамж бэхжинэ.



Тусламж үйлчилгээний Нэгдмэл загварчлалын танилцуулага



Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилгын талбай



Сумын Эрүүл Мэндийн Төвийн барилгын явц



ХУДНЭ-ийн барилгын гүйцэтгэгч компанитай хийсэн уулзалт



ХУДНЭ-ийн барилгын гүйцэтгэгч компанитай хийсэн уулзалт



Ховд аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч ажилтанд хийсэн сургалт







Булган аймгийн Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилгын талбай дээр



ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР

Эрүүл мэндийн байгууллагуудын анхан болон лавлагаа шатны тусламж, үйлчилгээний уялдаа холбоо сайжирч, орчин үеийн техник, технологийн шинэчлэл хийгдэж, оношилгоо, эмчилгээ үйлчилгээний нэр төрөл нэмэгдэн, үйлчлүүлэгчид ээлтэй чанартай тусламж үйлчилгээг өрх, сумын эрүүл мэндийн төвөөс 45,500 иргэд, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгээс 97,500 иргэд жилдээ авах нөхцөл бүрэн бүрдэнэ. Ингэснээр Монгол Улсын Эрүүл Мэндийн тогтолцоо нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас улс орон бүр дэвшүүлсэн "Бүх нийтийн эрүүл мэндийг хангаж, хэнийг ч үл үлдээх" зорилтыг хангахад чухал алхам болох юм.

Хаяг

-  Олимпын гудамж-2, Засгийн газрын 8 дугаар байр, ЭМЯ-ны өргөтгөл
-  [hspdpmongolia](#)
-  Эрүүл Мэндийн Салбарын Хөгжил Хөтөлбөр
-  www.hspd.org